

# СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Сүхбаатар аймгийн Онгон Арвижих ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** СБА-2022/05/НА-СТА-ОНӨААН

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт  
2022 он

Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 99029193

Цахим хаяг: [narantuyam@audit.gov.mn](mailto:narantuyam@audit.gov.mn)

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 99035990

Цахим хаяг: [davaag@audit.gov.mn](mailto:davaag@audit.gov.mn)

Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Захирал: А.Сарангэрэл

Утас: 9988 4842

Цахим хаяг: [gereltekhburtgelaudit03@gmail.com](mailto:gereltekhburtgelaudit03@gmail.com)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	7
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	7
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	7
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	7
4. Аудитын тайлан.....	9
4.1 Ерөнхий зүйл.....	9
4.2 Дотоод хяналт.....	9
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
4.4 Материаллаг байдал.....	10
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	11
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
8. Аудитын илрүүлэлт.....	11
8.1 Төлбөрийн акт.....	12
8.2 Албан шаардлага.....	12
8.3 Зөвлөмж.....	12
9.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	14

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль

## Аудитын санал дүгнэлт



### СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.03.16 № 142  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХАЛЗАН ДУЛААН ОНӨААТҮГ-ЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ О.БАЯРСАЙХАН  
ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Халзан дулаан ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Халзан дулаан ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулгыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд байгууллагын удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлан, тодруулгыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/Төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	19,548,313.94	45,501,067.96
1.1.2	Дансны авлага	3,776,377.00	10,793,836.00
1.1.6	Бараа материал	14,011,130.00	21,298,560.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>37,335,820.94</b>	<b>77,593,463.96</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,708,571,703.64	1,648,572,467.47
1.2.2	Биет бус хөрөнгө	4,785,900.00	4,587,900.00
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,713,357,603.64</b>	<b>1,653,160,367.47</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,750,693,424.58</b>	<b>1,730,753,831.43</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг		114,075.00
2.1.1.3	Татварын өр	4,856,791.85	4,886,165.22
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,600,208,495.95	1,569,860,893.66
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,605,065,287.80</b>	<b>1,574,861,133.88</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,605,065,287.80</b>	<b>1,574,861,133.88</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч-төрийн	13,038,400.00	13,038,400.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	132,589,736.78	132,589,736.78
2.3.10	Тайлант үеийн хуримтлагдсан ашиг		10,264,560.77
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>145,628,136.78</b>	<b>155,892,697.55</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,750,693,424.58</b>	<b>1,730,753,831.43</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

		/Төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>324,082,681.72</b>	<b>304,771,385.21</b>
2	Борлуулалтын өртөг	151,840,080.46	149,971,087.78
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>172,242,601.26</b>	<b>154,800,297.43</b>
4	Түрээсийн орлого	2,188,900.00	1,900,000.00
5	Хүүгийн орлого	231,419.68	
9	Борлуулалт, маркетингийн зардал	14,693,308.28	12,823,105.48
10	Ерөнхий ба удирдлагын зардал	131,346,965.29	131,917,263.44
11	Санхүүгийн зардал	85,975.18	84,460.00
12	Бусад зардал		470,401.00
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>28,536,672.19</b>	<b>11,405,067.52</b>
<b>19</b>	<b>Орлогын татварын зардал</b>	<b>2,853,667.22</b>	<b>1,140,506.75</b>
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>25,683,004.97</b>	<b>10,264,560.77</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>25,683,004.97</b>	<b>10,264,560.77</b>
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>25,683,004.97</b>	<b>10,264,560.77</b>
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

				/Төгрөгөөр/
Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан	Нийт дүн	

**Сүхбаатар аймгийн Онгон Арвижих ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

		ашиг	
<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>13,038,400.00</b>	<b>106,906,731.81</b>	<b>119,945,131.81</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>		25,683,004.97	<b>25,683,004.97</b>
<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>13,038,400.00</b>	<b>132,589,736.78</b>	<b>145,628,136.78</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		10,264,560.77	<b>10,264,560.77</b>
Өмчид гарсан өөрчлөлт			-
Зарласан ногдол ашиг			-
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>13,038,400.00</b>	<b>142,854,297.55</b>	<b>155,892,697.55</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>247,922,797.00</b>	<b>317,161,580.03</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	244,922,797.00	314,308,465.03
	Бусад мөнгөн орлого	2,363,400.00	2,853,115.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>254,160,962.21</b>	<b>291,208,826.01</b>
	Ажиллагчдад төлсөн	81,880,334.00	88,986,705.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	24,387,719.79	25,623,405.42
	Бараа материал худалдан авахад төлсөн		1,624,311.00
	Ашиглалтын зардалд төлсөн	53,637,296.71	62,488,572.51
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	58,551,396.00	78,518,069.00
	Татварын байгууллагад төлсөн	31,115,445.53	32,967,338.08
	Даатгалын төлбөрт төлсөн	290,850.00	322,725.00
	Бусад мөнгөн зарлага	4,297,920.18	677,700.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>(6,874,765.21)</b>	<b>25,952,754.02</b>
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>231,419.68</b>	
	Хүлээн авсан хүүгийн орлого	231,419.68	
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>231,419.68</b>	
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>6,643,345.53</b>	<b>25,952,754.02</b>
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	26,191,659.47	19,548,313.94
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,548,313.94	45,501,067.96

**2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

/Төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Дулааны орлого	311,194,290.12	286,500,000.00	291,281,874.77	(4,781,874.77)	101.7%
2	Ус түгээлтийн орлого	7,723,163.64	6,600,000.00	10,396,783.44	(3,796,783.44)	157.5%
3	Халуун ус	642,284.00	1,560,000.00	-	1,560,000.00	0.0%
4	Ковшийн төлбөр	4,754,363.64	1,600,000.00	3,092,727.00	(1,492,727.00)	193.3%
	<b>Борлуулалтын орлогын дүн</b>	<b>324,314,101.40</b>	<b>296,260,000.00</b>	<b>304,771,385.21</b>	<b>(8,511,385.21)</b>	
5	Түрээсийн орлого	2,188,900.00	2,500,000.00	1,900,000.00	600,000.00	76.0%
	<b>Нийт дүн</b>	<b>326,503,001.40</b>	<b>298,760,000.00</b>	<b>306,671,385.21</b>	<b>(7,911,385.21)</b>	
	Цалин хөлс	94,412,668.66	109,300,000.00	100,232,091.95	9,067,908.05	91.7%
	НДШ-ийн зардал	13,791,662.79	13,662,500.00	13,706,593.42	(44,093.42)	100.3%
	Албан татвар хураамж /Машины татвар бусад/	21,672,531.07	15,300,000.00	22,098,287.65	(6,798,287.65)	144.4%
	Бичиг хэргийн зардал	205,981.22	275,000.00	501,545.50	(226,545.50)	182.4%
	Ашиглалтын зардал	39,002,159.56	38,184,000.00	38,527,407.00	(343,407.00)	100.9%
	Хангамжийн материалын зардал	48,720,805.00	15,422,000.00	20,259,560.26	(4,837,560.26)	131.4%
	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардал	177,810.00		88,000.00	(88,000.00)	0.0%
	Сургалтын зардал		500,000.00		500,000.00	0.0%
	Шатахууны зардал	13,300,141.00	11,060,000.00	15,663,079.82	(4,603,079.82)	141.6%

**Сүхбаатар аймгийн Онгон Арвижих ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Даатгалын зардал	290,850.00	300,000.00	322,725.00	(22,725.00)	107.6%
Утас, интернэт	227,272.73	360,000.00	324,272.73	35,727.27	90.1%
Томилолт /унаа, буудал, хоол/	152,000.00	1,100,000.00	1,156,363.64	(56,363.64)	105.1%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал	3,764,741.00	1,700,000.00	2,818,300.00	(1,118,300.00)	165.8%
Банкны үйлчилгээний зардал	85,975.18		84,460.00	(84,460.00)	0.0%
Цэвэрлэгээний материалын зардал	1,287,909.00	500,000.00	1,431,293.92	(931,293.92)	286.3%
Хөдөлмөр хамгааллын зардал	489,313.00	1,390,000.00	3,214,983.64	(1,824,983.64)	231.3%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	58,953,509.00	60,193,000.00	66,795,629.00	(6,602,629.00)	111.0%
Сэлбэг хэрэгсэл	1,431,000.00	4,500,000.00	4,891,924.17	(391,924.17)	108.7%
Үндсэн хөрөнгө худалдаж авах зардал		2,000,000.00	3,149,800.00	(1,149,800.00)	157.5%
<b>Нийт дүн</b>	<b>297,966,329.21</b>	<b>275,746,500.00</b>	<b>295,266,317.70</b>	<b>(19,519,817.70)</b>	<b>107.1%</b>

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Онгон Арвижих ОНӨААТҮГ-ын зорилго нь “Дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай үнээр хангах, хэрэглэгчдийг дулааны эх үүсвэрээр найдвартай, зохицуулалттай үнээр хангах, эрхлэх үйл ажиллагаанд тогтоосон нөхцөл, шаардлагыг чандлан биелүүлж ажиллахад оршино” гэжээ.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын төвийн хүн амын байгууллага, аж ахуйн нэгжид стандартын шаардлага хангасан цэвэр усан хангамжийг бий болгох, усыг түгээх, ашиглалт, засвар үйлчилгээг хангах
- Хэрэглэгчийн хэрэглээний цэвэр усны алдагдлыг бууруулах, цэвэр усанд стандартын дагуу лабораторийн шинжилгээ хийлгэх
- Уст цэг, түгээх байрны ашиглалт, засвар үйлчилгээг хангах
- Бохирдсон усыг зохих стандарт, шаардлагын дагуу зайлуулах, цэвэрлэх, байгууламжийн ашиглалтыг хангах, засвар үйлчилгээг хийх
- Хэрэглэгчдэд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах, дулаан алдагдлыг бууруулах
- Даралттай шугам хоолой, түүний засвар угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ
- Нийтийн эзэмшлийн барилга байгууламж, зам талбай, шугам сүлжээ, техник тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ, технологийн шинэчлэлт хийх, түүнийг зориулалтын дагуу ашиглах
- Сумын төвийн хог хаягдлыг стандартын хүрээнд зайлуулах

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ОНӨААТҮГ статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

#### 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Сүхбаатар аймгийн Онгон сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 03 дугаартай тогтоолыг үндэслэн Онгон арвижих ОНӨААТҮГ-ыг байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дүгээр зүйлд “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхтэй: ... 5/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах,

өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих;...” гэсэн заалттай нийцэж байна.

Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн Б/09 дугаартай захирамжаар байгууллагын даргыг томилсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Онгон арвижих ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	19,548.3	45,501.1	25,952.8
Авлага	3,776.4	10,793.8	7,017.4
Бараа материал	14,011.1	21,298.6	7,287.5
Үндсэн хөрөнгө	1,708,571.7	1,648,572.5	59,999.2
Биет бус хөрөнгө	4,785.9	4,587.9	198.0
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,750,693.4</b>	<b>1,730,753.9</b>	<b>19,939.5</b>
Өр төлбөрийн дүн	-	114.1	114.1
Богино хугацаат өглөг	4,856.8	4,886.2	29.4
Урьдчилж орсон орлого	1,600,208.5	1,569,860.9	30,347.6
Эздийн өмч	145,628.1	155,892.7	10,264.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,750,693.4</b>	<b>1,730,753.9</b>	<b>19,939.5</b>

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 45,501.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын дансны үлдэгдэл 10,793.8 мянган төгрөг болж, 7,017.4 мянган төгрөгөөр өссөн нь Монгол улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дугаар тогтоолоор ус, дулааны төлбөрийг төрөөс хариуцан төлөхтэй холбоотой Эрчим хүчний яамнаас авах 10,145.3 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байгаа нь нөлөөлжээ.

Авлагын дансны үлдэгдэлд хувь хүнээс авах 470.4 мянган төгрөгийн авлагатай байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 21,298.6 мянган төгрөг болж, 7,287.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 37,741.3 мянган төгрөгийн нүүрс худалдан авсан нь голлон нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,648,572.5 мянган төгрөг болж, 59,999.2 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн данс 3,149.8 мянган төгрөгийн худалдан авалтаар нэмэгдэж, 63,149.0 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан байна.

Биет бус хөрөнгийн дансны үлдэгдэл 4,587.9 мянган төгрөг болж, 3,102.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд тооцсон элэгдлээс шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд ААНОАТ-т өгөх 1,140.5 мянган төгрөгийн, НӨАТ-т өгөх 3,745.7 мянган төгрөгийн, ХЧТА-ын тэтгэмжийн 114.1 мянган төгрөгийн, нийт 5,000.2 мянган төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

### **3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Онгон арвижих ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сүхбаатар аймгийн Онгон сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 09 дугаар сарын 04-ний өдрийн 15 дугаар тогтоолоор Онгон арвижих ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 298,760.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 275,746.5 мянган төгрөгөөр, 20,712.2 мянган төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 306,671.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 295,266.3 мянган төгрөгийн зардал гарган, 10,264.6 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 306,671.4 мянган төгрөг болж төлөвлөснөөс 7,911.4 мянган төгрөг буюу 2.7 хувиар давж биелсэн байна. Энэ нь том оврын машин механизмаар элс түрэх, нүх ухах зэрэг үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотой нэмэгдсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 295,266.3 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 19,519.8 мянган төгрөгөөр буюу 7.8 хувийн илүү гүйцэтгэлтэй байна. Үүнд шатах тослох материалын үнэ нэмэгдсэн, БНХАУ-ын хийл хаагдсантай холбоотой нүүрс нөөцөлсөн зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Тайлант онд цэвэр ашиг 10,264.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 10,447.6 мянган төгрөгөөр дутуу байгаа нь орлогын гүйцэтгэл 102.7 хувиар давж биелсэн, зардлын гүйцэтгэл 107.8 хувиар илүү зарцуулалттай байгаагаас шалтгаалжээ.

## **4. Аудитын тайлан**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Онгон Арвижих ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторын туслах Э.Алтангэрэл, аудиторын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, Дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа, Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн Чанарын хяналтын менежер Д.Батмөнх, Захирал А.Сарангэрэл нар хэрэгжүүлсэн.

Онгон Арвижих ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан тодруулгыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Дотоод хяналт**

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй/шаардлагатай гэж үзлээ.

#### **4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Онгон Арвижих ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### **4.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангаас нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогоос 2.0 хувиар буюу 6,530.1 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувиар буюу 5,224.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос 2.0 хувиар буюу 6,133.4 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 80 хувиар буюу 4,906.7 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 396.6 мянган төгрөгөөр буурсан байна.

## **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Онгон Арвижих ОНӨААТҮГ нь 2021 онд нийт 731,134.4 мянган төгрөгийн 29 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 698,059.4 мянган төгрөгийн 18 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилтэй байна.

### **5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

МУЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **6.2. Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт:**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Сүхбаатар аймгийн Төрийн аудитын газраас итгэл үзүүлсэн байна.

## **7. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Сүхбаатар аймгийн Онгон Арвижих ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

Дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

## **8. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 702,526.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 156.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт, 3,996.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага, 698,529.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

### **8.1 Төлбөрийн акт**

- 1. Нийт 20 ажилтны цалингаас ХХОАТ-ын хөнгөлөлт тооцохдоо Нийгмийн даатгалын шимтгэлийг хассан дүнгээс суутган тооцолгүй, олговол зохих цалингаас суутган тооцож тайлагнаснаас 156.8 мянган төгрөг илүү суутгасан.*

ХХОАТ-ын тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.1-д " Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна", 23 дугаар зүйлийн 23.1-д "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

## 8.2 Албан шаардлага

Нийт 3 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 2,580.0 мянган төгрөгийн, 3 хувь хүмүүстэй холбоотой 1,416.7 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т "Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй", "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

## 8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Авлагын данстай холбоотой асуудал

#### 1.1 Илрүүлэлт:

Авлагын дансны үлдэгдэлд 2017 онд үүссэн 1 харилцагчийн 470,401.0 төгрөгийн он дамжсан авлагатай байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасан "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах,,," заалт, мөн хуулийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалт, УСНББОУС-ын үндсэн шаардлага, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 1.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар журмыг мөрдөн ажиллах, үүссэн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, баримтжуулах, авлагыг барагдуулах арга хэмжээ зохион байгуулах, авлагыг барагдуулах

### 2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

#### 2.1 Илрүүлэлт:

Байгууллагын дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй 11 ширхэг 105,474.3 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд

хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2 “Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна”, 6.2.1 “элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон” заалт, УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”-д тавигдах шаардлага, “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## 2.2 Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоож, холбогдох эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

## 3. Шилэн данстай холбоотой асуудал

### 3.1 Илрүүлэлт:

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудаст нийт 731,134.4 мянган төгрөгийн 29 мэдээллийг ил тод байршуулахаас 698,059.4 мянган төгрөгийн 18 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/ д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Цалинг буруу тооцоолон олгосон	1	156.8			1	156.8				
2	Худалдан авалтыг татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдоогүй	1	3,996.7					1	3,996.7		
3	Он дамжсан тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй авлага бүртгэгдсэн	1	470.4							1	470.4
4	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна	1	-							1	-
Дүн		4	4,623.9	-	-	1	156.8	1	3,996.7	1	470.4
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	698,059.4							1	698,059.4
Дүн		1	698,059.4	-	-	-	-	-	-	1	698,059.4
Нийт дүн		5	702,683.3	-	-	1	156.8	1	3,996.7	3	698,529.8